

ХҮҮ-ХҮШ зууны үеийн монгол хууль цаазын бичгүүд дэх байгаль хамгаалах үзэл санаанд бурхны шашны сургаал нөлөөлсөн нь

С.Янжинсүрэн, доктор (Ph.D), гэрээт профессор
МУИС, Философи, шашин судлалын тэнхим.

Д.Юмчинхорлоо, доктор (Ph.D)
Ерөнхийлөгчийн Тамгын газар

Хураангуй: Хүн төрөлхтний өмнө байгалийн төрөл бүрийн гамшиг олон тоогоор, ойрхон давтамжтай тохиолдох болсны шалтгааныг байгаль шинжлэлийн салбарынхан байгалийн жам ёсны үзэгдлээс гадна хүний хэрэглээний өсөлт болон байгальтай зүй бус харьцаж байгаа хүний үйлдэлтэй холбон үзэж байгаа ба хүний энэ хандлага нь өөрийнх нь оршихуйн үндсэн нөхцөл болсон байгалийн унаган төрхийг алдагдуулж байгаа гол хүчин зүйл мөн хэмээн үзэх болоод нэлээд хугацаа өнгөрч байна. Тиймээс хүн төрөлхтөн нийтээрээ байгаль дэлхийнхээ унаган төрхийг хадгалах, алдагдахаас нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх болсон юм. Ард түмнүүдийн уламжлалт мэдлэг ухаан, соёл, амьдралын хэв маяг, зан үйлд нь байгальд ээлтэй мэдлэг, арга ил хийгээд далд хэлбэрээр хадгалагдаж байгааг дэлхийн соёлын өвийг хамгаалах чиг үүрэгтэй байгууллагууд анхаарч тал бүрээр судалгаа хийж илрүүлэн, үр дүнг нь нийтэд толилуулан сурталчилж байгаль хамгаалах соёлыг шинэ төвшинд гаргахаар ажиллаж байна. Үүнд, НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага ЮНЕСКО тодорхой жишээ нь болж байгаа бөгөөд их дээд сургуулиуд, судалгааны хүрээлэнгүүд ч үүнд онцгой үүрэг гүйцэтгэж байгаа болно. Ер нь аливаа мэдлэгийг өөртөө болон эх дэлхийдээ ач холбогдолтойгоор хэрэглэх нь мэдлэгийн хэрэглээний үндсэн шаардлага мөн юм. Монголчуудын хувьд, байгаль хамгаалах төрөл бүрийн мэдлэг, арга ухаан, зан үйлтэй. Ингэхдээ байгаль хамгаалах үзэл санаа, арга, зан үйлийг хуульчлан тогтоож мөрдүүлэн нүүдэлчин аж ахуйгаа дэмждэг байсан нь Их засаг тэргүүтэй Монгол төрийн хууль цаазын бичгүүдэд тусгалаа олжээ. Тэрчлэн тэдгээр хуулиуд дахь байгаль хамгаалах үзэл санаа, зүйл заалтад нь монгол газарт эртнээс суурьшсан Буддын шашны үзэл баримтлал нөлөө тусгалаа олсон байна. Ялангуяа Монгол дахь бурхны шашны дэлгэрэлтийн гутгаар үеийг өмнөх хоёр үетэй нь харьцуулахад цар хүрээний хувьд өргөн бөгөөд зөвхөн хаад ноёдын хүрээгээр хязгаарлагдахгүй нийт ард олны дунд түгэн дэлгэрч, монголчуудын ахуйд нь тод тусаж, дасаж хөгжсөн онцлогтой. Бурхны шашны үзэл сургаал монголчуудын ахуй амьдралын бүхий л салбарт нөлөөлсний тодорхой илрэл нь Халх журам тэргүүтэй хууль эрхзүйн эх сурвалжуудаар нотлогдож байна. Энэхүү өгүүлэлд монгол нутаг дахь бурхны шашны хөгжлийн гурав дахь үед холбогдох хууль цаазын бичгүүдэд тулгуурлан монголчуудын байгаль хамгаалах үзэл санаанд тус шашны сургаал хэрхэн туссаныг авч үзлээ.

Түлхүүр үг: Монгол хууль, хууль цаазын бичиг, байгаль хамгаалал, бурхны шашны үзэл санаа, Монголын бурхны шашны хөгжлийн гуравдугаар үе.

Оршил. Хүн төрөлхтний өмнө байгалийн төрөл бүрийн гамшиг олон тоогоор, ойрхон давтамжтай тохиолдох болсны шалтгааныг байгаль шинжлэлийн салбарынхан байгалийн жам ёсны үзэгдлээс гадна хүний хэрэглээний өсөлт болон байгальтай зүй бус харьцаж байгаа хүний үйлдэлтэй холбон үзэж байгаа ба хүний энэ хандлага нь өөрийнх нь оршихуйн үндсэн нөхцөл болсон байгалийн унаган төрхийг алдагдуулж байгаа гол хүчин зүйл мөн хэмээн үзэх болоод нэлээд хугацаа өнгөрч байна. Тиймээс хүн төрөлхтөн нийтээрээ байгаль дэлхийнхээ унаган төрхийг хадгалах, алдагдахаас нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх болсон юм.

Ард түмнүүдийн уламжлалт мэдлэг ухаан, соёл, амьдралын хэв маяг, зан үйлд нь байгальд ээлтэй мэдлэг, арга ил хийгээд далд хэлбэрээр хадгалагдаж байгааг дэлхийн соёлын өвийг хамгаалах чиг үүрэгтэй байгууллагууд анхаарч тал бүрээр судалгаа хийж илрүүлэн, үр дүнг нь нийтэд толилуулан сурталчилж байгаль хамгаалах соёлыг шинэ төвшинд гаргахаар ажиллаж байна. Үүнд, НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага ЮНЕСКО тодорхой жишээ нь болж байгаа бөгөөд их дээд сургуулиуд, судалгааны хүрээлэнгүүд ч үүнд онцгой үүрэг гүйцэтгэж байгаа болно. Ер нь аливаа мэдлэгийг өөртөө болон эх дэлхийдээ ач холбогдолтойгоор хэрэглэх нь мэдлэгийн хэрэглээний үндсэн шаардлага мөн юм.

Монголчуудын хувьд, байгаль хамгаалах төрөл бүрийн мэдлэг, арга ухаан, зан үйлтэй. Ингэхдээ байгаль хамгаалах үзэл санаа, арга, зан үйлийг хуульчлан тогтоож мөрдүүлэн нүүдэлчин аж ахуйгаа дэмждэг байсан нь Их засаг тэргүүтэй Монгол төрийн хууль цаазын бичгүүдэд тусгалаа олжээ. Тэрчлэн тэдгээр хуулиуд дахь байгаль хамгаалах үзэл санаа, зүйл заалтад нь монгол газарт эртнээс суурьшсан Буддын шашны үзэл баримтлал нөлөө тусгалаа олсон байна.

Ялангуяа Монгол дахь бурхны шашны дэлгэрэлтийн гутгаар үеийг өмнөх хоёр үетэй нь харьцуулахад цар хүрээний хувьд өргөн бөгөөд зөвхөн хаад ноёдын хүрээгээр хязгаарлагдахгүй нийт ард олны дунд түгэн дэлгэрч, монголчуудын ахуйд нь тод тусаж, дасаж хөгжсөн онцлогтой. Бурхны шашны үзэл сургаал монголчуудын ахуй амьдралын бүхий л салбарт нөлөөлсний тодорхой илрэл нь Халх журам тэргүүтэй хууль эрхзүйн эх сурвалжуудаар нотлогдож байна.

Энэхүү өгүүлэлд монгол нутаг дахь бурхны шашны хөгжлийн гурав дахь үед холбогдох хууль цаазын бичгүүдэд тулгуурлан монголчуудын байгаль хамгаалах үзэл санаанд тус шашны сургаал хэрхэн туссаныг авч үзлээ.

Нэг. Монголчуудын хууль эрх зүй ба байгаль хамгаалах үзлийн уламжлал

Монгол төр эрх зүй нь эртний уламжлалтай. Монгол нутаг дахь анхны төрт улс Хүннү улс нь зан заншлын эрх зүйтэй байсан тухай судлаачид тэмдэглэдэг. Тухайлбал академич Ч.Жүгдэр “Хүннүгийн хууль бол бичигдэл бус, овгийн байгууллаас уламжлалттай аливаа хориглох заншилд тулгуурласан феодалын хэв хуулийн шинжтэй байсан гэж үзэх үндэстэй” (Ч.Жүгдэр, 1987, хууд. 93) хэмээжээ.

Мөн түүнчлэн эртний хятадын сурвалж бичиг “Түүхийн тэмдэглэл”-д: “тэдний баримталдаг хуулиар эрт үзүүртийг гаргавал цаазаар аваачна, хулгайн ялтай хүний гэр бүлийг хураана, хөнгөнийг бэрээднэ, хүндийг цаазаар авна” (Ж.Болдбаатар нар, 2011, хууд. 25) зэргээр тэмдэглэсэн байна.

Хүннү гүрний дараа тогтсон Сяньби улс “...эрхийн заншилд дулдуйдаж гэрээ, соёрхол бичиг, дүрэм, эцэст нь хууль гаргасан билээ.” (Ч.Жүгдэр, 1987, хууд. 94) Нэг үгээр хэлбэл Сяньбичууд Хүннүчүүдийн төр ёс, хууль цаазыг залгамжлан авсан бөгөөд анхандаа хэв хуультай байсан авч, хожмоо бичмэл хуультай болсон байна.

Энэ мэт монгол нутаг дахь эртний улсууд зан заншил хийгээд эрх зүйн хэм хэмжээг хамтад нь хэрэглэж байв.

1206 онд Тэмүжин анх удаа бүх монгол аймгийг нэгтгэсэн Их монгол улсыг байгуулсан. Чингис хаан их ор суух үедээ “Их засаг” хуулийг тунхагласан (Сайшаал, 2008, хууд. 395) юм.

“Их монгол улс өргөжин бэхжихийн хэрээр эрх зүйн болон заншлын хэм хэмжээ нь ялгамж, онцлогоороо тодорч, харилцан бие биедээ нөлөөлөн, монголын нийгмийн харилцааны нарийн түвэгтэй байдлыг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн” (Ж.Болдбаатар нар, 2011, хууд. 82) байна.

“Их засаг” хууль бүрэн эхээрээ бидэнд уламжлагдан ирээгүй ч эрдэмтэд “Монголын нууц товчоо”, “Богд баатарын биеэр дайлсан тэмдэглэл”, “Судрын чуулган”, “Дэлхийг байлдан

дагуулагчдын түүх” зэрэг сурвалжуудад үндэслэн бүтэц агуулгыг нь тодорхойлдог. Зарим судлаач³⁷ “Их засаг” хуулийг ерөнхий хууль буюу үндсэн хууль, хаан төрийн тухай хууль, эрүүгийн хууль, цэрэг дайны тухай, ард иргэдийн тухай, олон улсын харилцааны тухай, аж ахуйн тухай, арилжаа худалдааны тухай, шашин суртахуун зэрэг агуулгыг багтаасан хэмээн үзсэн нь бий. “Их засаг” хууль бол нийгмийн нэг төрлийн харилцааг зохицуулсан бус, харин олон төрлийн харилцааг зохицуулсан нэгдмэл хууль байсан (Ж.Болдбаатар нар, 2011, хууд. 82) гэдэг. Түүнд “өвс ногоорсон хойно газрыг нүхэлсэн ба гал алдаж бэлчээрийг шатаагсдын нэгэн гэрийг алмуй.” (Сайшаал, 2008, хууд. 403); “... гараа урсгал усанд угаадаггүй...”; “хэн усанд шумбана тэр шийтгэгдэнэ” (Ц.Минжин, 2009, хууд. 249) гэх зэргээр монголчуудын байгаль хамгаалалтай холбогдох зүйлийг тусгажээ.

Монголчууд эртнээс нүүдлийн мал аж ахуйг эрхэлсэн тул “монголчуудын мэдлэг ухаан ... нүүдлийн мал аж ахуйтай нягт холбоотой хөгжиж иржээ”. (Ч.Жүгдэр, 1987, хууд. 67) Ийм ахуй амьдралын гол эх сурвалж болох бэлчээрийг хамгаалах шаардлага зүй ёсоор урган гарна. Тэр ч утгаар бэлчээрийг сүйтгэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага чанга байсан нь харагдаж байна.

Мөн түүнчлэн гол усыг бохирдуулахыг хатуу хориглож байжээ.

Тэрчлэн Монголын эзэнт гүрний үед улсын их ан ав нь тусгай дүрэмтэй байсан бөгөөд “өвлийн их паснаас эхэлж, дараа хавар ногоо соёолтол” (Сайшаал, 2008, хууд. 403) зэрлэг амьтдыг авладаг байсан нь амьтдын нөхөн үржих цаг хугацааг тооцож байсны илрэл буюу байгаль экосистемийн тэнцвэрийг хадгалах бодлого байв.

Хубилай хааны байгуулсан “Их Юань хэмээх Их Монгол Улс”-д (Д.Идэр, 2019) “Ярьж эмхэтгэсэн хуулийг бичиг” (1262), “Шинэ эмхэтгэсэн хуулийн бичиг (1264), “Эрхэн зөвлөлийн яамнаас өргөн боловсруулсан хуулийн бичиг (1271), “Жи Юанийн шинэ хууль” (1291), “Нэгдлийн анхлагч нарын хууль” (1311) зэрэг хэд хэдэн хууль батлан хэрэгжүүлжээ.

Тэдгээрээс нэлээд бүрэн хэмжээний томоохон хууль нь “Их Юанийн нэвтэрхий хууль”³⁸ юм. Уг хуулийн ерөнхий агуулга Юань Улсын сударт хадгалагдсан бөгөөд үндсэн гурван хэсэгтэй. Тэдгээр нь: “нэгдүгээрт, зарлигийн хууль хоёрдугаарт дүрэм, журам, гуравдугаарт, таслах дүрэм” (СунЛянь, 102 дугаар дэвтэр) тус тус болно.

Ерөнхийдөө Юань улсын үеийн хуулиудын “газар, хөрс, ус, ой мод, ан амьтныг хамгаалах, ан ав хийх, ой хээрийг түймрээс хамгаалахтай холбоо бүхий эрх зүйн хэм хэмжээ нь Их засаг хуулийн агуулгатай төстэй” (О.Амархүү, 2000) юм.

Монголчууд Хятад дахь ноёрхлоо 1368 онд алдаж, Бээжинг орхин уугуул нутагтаа эргэн ирсэн түүхтэй. Гэвч монгол нутагтаа сууж байсан ноёд хаанд захирагдалгүй, биеэ даахыг эрмэлзэж байсан нь улс төрийн тогтворгүй байдал, хагарал бутралын үндэс болсон юм. Эл бүхий нөхцөл байдалтай уялдан тухайн үеийн хууль цаазын бичгүүдэд монголчуудын эв нэгдлийг хангах үзэл санаа гүнзгий тусжээ.

Хоёр. Монгол хууль дахь байгаль хамгаалах үзэл санаанд бурхны шашны сургаал туссан нь.

Улсыг, төрийг удирдах сонирхолтой хэсэг нь тархай бутархай ард түмнийг нэгтгэх хүчин зүйлсийг хайх нь зүй ёсны үзэгдэл бөгөөд тийм нэгтгэгч хүчин зүйл нь шашин, ялангуяа бурхны шашин гэж үзэх хандлага энэ үеэс монголчуудад тогтсон юм. Монголчууд бурхны шашныг

³⁷ Тухайлбал Чингис хааны намтар түүхийн талаар хамгийн дорвитой бүтээлийн нэгийг туурвисан эрдэмтэн Сайшаал бээр “Чингис хааны товчоон” хэмээх бүтээлдээ Их засаг хуулийн дурдсан бүлгээр нийт 54 зурвас (заалт)-ыг тэмдэглэжээ.

³⁸ Тус хууль нь 1323 онд буюу Шадбал гэгээн хааны үед зохиогджээ. Юань улсын судар. 102 дугаар дэвтэр. УТНС дахь гар бичмэл.

сонгосон шалтгааныг монгол орны газар зүйн байрлал, дорно дахины ард түмнүүдэд бурхны шашин түгэн дэлгэрсэн байдал болон тэдний геополитиктой шууд холбож үзэх ёстой юм. Энэ үед энэтхэгээс гарсан бурхны шашин дорно дахиныг бүхэлд нь хамарч, бурхны шашны эд хэрэглэлийн үйлдвэрлэл нэн эрчимтэй хөгжиж байсан юм.

Нөгөөтэйгүүр, аажимдаа монгол ноёд нэгэн шашны дор нэгдэх бодлого баримтлах болсноор монголд бурхны шашин хүчтэй дэлгэрч эхэлсэн бөгөөд Түмэн Засагт хан (1539-1592) Төвөдийн Гармава³⁹ урсгалын тэргүүн Гарма ламыг, Түмэдийн Алтан хан (1508-1582)⁴⁰, Халхын Автай хан (1554-1588)⁴¹ нар ээлж дараагаар тухайн үеийн төвөдийн бурхны шашны тэргүүн Содномжамцыг (1543-1588) тус тус залж авчран (1578; 1586) багш шавийн барилдлага тогтоож, улмаар Далай лам хэмээх цол өргөсөн зэрэг үйл явдлуудаар монголын бурхны шашны түүхийн гуравдахь үе эхэлсэн байдаг юм. Түмэдийн Алтан ханыг чакраварди буюу хүрдэн эргүүлэгч Алтан хаан (Чакраварди Алтан хааны тууж. Хөрв. Д.Заяабаатар, 2006) хэмээдэг нь түүнийг бурхны шашныг монгол оронд дэлгэрэн хөгжихөд үлэмж зүтгэсэн болохыг харуулна.

Өгүүлэн буй гуравдугаар үе нь өмнөхүүдтэй харьцуулахад илүү өргөн цар хүрээтэй, нийт ард олныг хамарсан онцлогтой тул нийт монголчуудын үзэл санаанд нөлөөлсөн нь тухайлахад монголчуудын байгаль хамгаалах үзэл санаанд тодорхой тусгалаа олжээ. Жишээлбэл, энэ үед монголд “Алтан ханы цаазын бичиг”, “Хутугтай сэцэн хунтайжийн цааз”, “Халхын цааз эрхэмжийн бичиг”, “Монгол-Ойрадын хууль”, “Халх журам” зэрэг хууль цаазын бичгийг боловсруулан хэрэгжүүлсэн ба тэдгээр дэх байгаль хамгаалах тухай үзэл санаанд бурхны шашны сургаал, номлол нөлөөлсөн байгаа нь тодорхой байна.

“Алтан ханы цааз” нь монгол хэлт эхээр бус харин төвөд орчуулгаар, бүр төвөд бичгийн таталган бичлэг-шар үсгээр бидний үед уламжлагдан ирснийг академич Ш.Бира сэргээн толилуулсан байдаг. Тус цааз нь тодорхой бүлэг зүйлд хуваасан зүйл үгүй боловч “...эрт урьдын тодорхой зарга арван гурвыг тунгаасан гол ном төгссөн болой” (Б.Баярсайхан, 2002, хууд. 22) хэмээсэн байх тул 13 зүйл ангитай байсан болов уу гэж судлаачид таамагладаг. Энэхүү Алтан ханы цаазад байгаль хамгааллын тухай доорх байдлаар дурджээ.

“... Хулан, тахийг алваас таваар торго”, “... хандгай, эр эм гөрөөсийг алваас таван хониор торго”, “эр эм буга, бодон гахай алваас таван үхрээр торго”; “тэх, ямаан гөрөөс хүдэр алваас таван ямаагаар торгоно”; “илбэнх, дорго, алваас таван хониор торго; “туулайг албал арван туулай тутам нэг хонь, тав тутамд нэг ямаа ав”, “... нохойг зэрлэгээр алваас морь үхэр ав” (Б.Баярсайхан, 2002, хууд. 19) Эндээс үзэхэд том, бага гэлтгүй аливаа амьтдыг алж хөнөөх нь цөм шийтгэл хүлээхээр заасан байна. Энэ нь нэг талаас бурхны шашны “амьтны амь таслах нь нүгэл” болох тухай үзэл санааны тусгал мөн гэж үзэж байна. Нөгөөтэйгүүр амьтан бүрийг хөнөөхөд оногдуулах шийтгэл нь харилцан адилгүй байгааг тухайн амьтны тоо толгойтой холбон үзэж байсан байна гэж дүгнэж байна. Нэг үгээр хэлбэл монголчууд тухайн үед экосистемийн тэнцвэрийг харгалзан үзсэн байх.

“Хутугтай сэцэн хунтайжийн цааз” нь мөн л бүрэн эхээрээ хадгалагдан үлдээгүй тул Саган сэцэний “Эрдэнийн товч” хийгээд V Далай лам Агваанжамцын (1617-1682) зохиосон III Далай лам Содномжамцын намтар зохиолд өгүүлснээр авч үздэг. Академич Ш.Бирагийн тэмдэглэснээр, Хутагтай сэцэн хунтайж⁴² бээр “Арван буянт номын цагаан түүх”-ийн үндсэн дээр уг цаазыг зохиожээ. “Хутагтай сэцэн хунтайжийн цааз”-д:

³⁹ XI зуунд Төвөдөд үүссэн бурхны шашны урсгал.

⁴⁰ Батмөнх даян хааны хүү Барсболд хааны хоёрдугаар хүү.

⁴¹ Батмөнх даян хааны отгон хүү Гэрсэнз жалайр хун тайжийн долоон хүүгийн дундах Онохуй Үйзэн ноёны ахмад хөвүүн.

⁴² Хутагтай сэцэн хунтайж Алтан ханы шадар түшмэл бөгөөд 1540-1586 оны хооронд амьдарч байжээ.

...“Урьд монгол улс хүн үхвээс, чинээ чинээгээрээ тэмээ морийг алж хойлго хийн хамт булах бөлгөө. Өдгөө түүнийг тэвчиж чинээ чинээгээрээ номын зүгт зорьтугай” (Э.Авирмэд, 1997, хууд. 42) хэмээсний “номын зүгт” гэдэг нь бурхны шашныг хэлсэн хэрэг мөн.

Цааш нь “Сарын гурван мацагийн өдөр малын амь таслах, гөрөөс шувуу авлахыг тэвчсүгэй” (Э.Авирмэд, 1997, хууд. 42) гэсэн нь бүхэлдээ бурхны шашны үзэл санааг илэрхийлж буй юм. Бурхны шашны заншилд шинийн 8, 15 болон битүүнийн өдрүүдэд мах идэхийг цээрлэж, цагаан хоол идэж, амьтны амийг хэлтрүүлдэг хорио цээрийн ёстой юм.

Мөн түүнчлэн “Увш, убшинз нар номын төрөөс давж амь нядалбаас урьдчилан гэсгээгээд албанд оруултугай” (Б.Баярсайхан, 2002, хууд. 19) хэмээсэн нь нэг талаар амьтны амь хөнөөхийг цээрлэхийн зэрэгцээ хуврагуудын сахил санваарыг цаазалсан зүйл юм. Увш (Uṣṣaka), увшинз (Uṣṣikā) хэмээх нь бурхны шашинтны гэнэн (буяны садан эрэгтэй), гэнэнмаа (буяны садан эмэгтэй) сахилын санскрит нэр болно. Энэ сахилыг хар хүн ч сахиж болдог ба амьтны амь таслах, худлаа ярих, хулгай хийх, архи согтууруулах ундаа хүртэх, буруу хурьцал үйлдэхийг тус тус тэвчих ёстой ч эдгээр таваас аль сахиж чадахаа сонгож сахиж ч болдог онцлогтой. Харин Хутугтай сэцэн хунтайжийн цаазад амьтны амь хөнөөхийг увш, увшанз нарт бүгдэд нь хоригложээ.

“Хутагтай сэцэн хун тайжийн цааз” монголд бөө мөргөлийг бурхны шашнаар, гэлүгвийн ёсоор сольж, байр суурийг нь бэхжүүлэх үндсэн шаардлагаар зохиогдсон тул тэр хэрээр бурхны шашны үзэл санааг гүнзгий тусгасан нь тодорхой байна.

“Халхын цааз эрхэмжийн бичиг”⁴³ бол “XVI зууны хоёрдугаар хагасаас ХҮШ зууны дөчөөд он хүртэлх хугацаанд халхын дөрвөн хошуу, зургаан хошуу, долоон хошуудын ноёдын арван найман удаагийн чуулганаар хэлэлцэн тогтоосон арван найман цаазын хураамж-хуулбар юм.” (Э.Авирмэд, 1997, хууд. 53) Түүнд: “хэн хүн адгуусыг шаналж харваж албал...”, (Б.Баярсайхан, 2002, хууд. 23) “түймэр алдсан хүнийг хэн үзсэн хүн нэг морь тавлаж ав. Түлсний алданги тавт. Юугаар түлвэл төлдөстэй буй. Хүн үхвэл анзаар болов. (Б.Баярсайхан, 2002, хууд. 26), “...Хавх, тас, бүргэд, харцагын доор гурван ёст” (Б.Баярсайхан, 2002, хууд. 35) “Бурхны цагаан /мөрт/ замд могой, мэлхий, ангир, болжмор, ... нохой эдийг алваас нэг морьт” (Б.Баярсайхан, 2002, хууд. 36) хэмээн хэм хэмжээг тогтоосон байна. Энд мал аж ахуй гол амьжиргаа нь болдог ард түмнийхээ хувьд малын бэлчээрээ гамнан хамгаалсан, гал түймэрээс урьдчилан сэргийлсэн байхаас гадна бурхны шашны тогтоосон хорио цээрийг сахиулах агуулга өгүүлэмжээс нь тодорхой байгаа юм.

“Монгол Ойрадын Их цааз”-ыг Түшээт хан Гомбодорж, Ойрадын Эрдэнэбаатар хунтайж, Гүүш хан Төрбайх тэргүүтэй 28 ноёд 1640 оны наймдугаар сард Тарвагатайн Улаанбураа хэмээх газар чуулж тогтоожээ. Уг хуулийг зарим судлаач “...харийн түрэмгийлэл нүүрлэж байсан тэрхүү бачим тулгуу цагт хүн ардын сонор сэрэмжийг дээшлүүлж, нийт монголчуудын эв нэгдлийг эрхэмлэх, олны дотор шарын шашны нэр нөлөөг өргөж, эрх дархыг нэмэгдүүлэх, эзэн харьяатын ёсыг бэхжүүлэх, үүнтэй холбоотойгоор тухайн нийгмийн харилцааны олон талыг эрх зүйн хувьд зохицуулахад чиглэж байв. (Ж.Болдбаатар нар, 2011, хууд. 155) хэмээн дүгнэсэн нь бий.

Түүнд “... өшиж түймэр тавихул их бэрхээр болтугай.” (Б.Баярсайхан, 2002, хууд. 42) хэмээн өмнөх хуулиудын адил малын бэлчээрээ хамгаалсан заалт байх бөгөөд цааш нь “... нүүсэн нутгаас хүн гал унтраахул хонь ав”, “түймэр, ус хоёрт үхэх хүнийг авахул тав ав”, “түймэр ус хоёрт туслана гэж хүн үхэхүл бэрхтэй ес ав” (Б.Баярсайхан, 2002, хууд. 42) хэмээжээ.

⁴³ Өөрөөр “Халхын үйсэн дээрх бичиг”, “Халхын үйсэн дээр бичсэн цааз” ч гэх бөгөөд 1970 онд Х.Пэрлээ нар Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг дахь “Хар бухын балгас”-наас олжээ.

“Монгол Ойрадын Их цааз”-ын бусад хуулиудтай харьцуулбал онцлог нэг зүйл буй нь “... зудагд үхсэн малын зовлого арав хоногоос нааш авхул гунж ав” (Б.Баярсайхан, 2002, хууд. 45) гэсэн заалт болно. Малын сэг зэм нь эрүүл ахуйн хувьд байгаль орчинд сөрөг нөлөөтэй тул түүнийг аль болох түргэн цэвэрлэх нь чухал тул уг заалт нь тухайн үедээ ихээхэн дэвшилт үзэл санаа болжээ гэж бид үзэж байгаа юм.

Мөн “... булган, үнэгэн, хэрмэн, хярсан, мануул, цоохондой үен эднээс бага араатныг ахлан ихээс нь гунж, багаас нь хонь ав, хавхад унасан араатан эднийг хэвээр болов” (Б.Баярсайхан, 2002, хууд. 44) хэмээсэн нь мөн л амьтны амийг хөнөөхийг хориглон хуульчилсан зүйл мөн.

“Халх журам” нь Монголын бурхны шашны хөгжлийн энэ үед холбогдох боловч монгол манжийн эрхшээлд орсон үед боловсруулж хэрэгжүүлсэн, өмнөх хууль цаазын бичгүүдээс ялгаатай “монголын түүхийн болон монгол хууль цаазын нэн чухал баримт бичиг” бөгөөд “Монгол манжид эзлэгдсэнээс хойш арван найман жилийн дараа бичигдсэн учир Монгол орон манж гүрний зах хязгаар болон хувирсан үеийн түүхэн нөхцөл байдал энэ хуульд зохих тусгалаа олсон” (Жалан-Аажав, 1995, хуудсд. 3-4) байдаг юм.

1709-1795 оны хооронд халхын ноёд 10 гаруй удаа хуралдан хэлэлцэн тогтоосон цаазуудаас бүрдэх тус хууль өдгөө “Их хүрээний шавь яамны Халх журмын дүрэм”, “Баруун хүрээний Халх журам” гэсэн агуулгын хувьд бараг ижил хоёр янзын хуулбар эхээр уламжлагдан иржээ.⁴⁴

Энэ өгүүлэлд бид “Баруун хүрээний Халх журам”-ыг эх болгон зарим санааг тодорхой авч үзэж байна. “Баруун хүрээний халх журамд монголчуудын байгаль хамгаалах үзэл санаанд холбогдох дор дурдсан зүйлс байна. Үүнд:

“...хүрээ зассан газар хүрээнээс дотогш хуурай, нойтон аль ч мод огтлохгүй. Хүрээний захаас гадагш гарваас он тусч хүрэхээс нааш нойтон мод огтлохгүй.” , “хуурай мод огтолсон, нойтон модыг хуга дайрваас шилэрсэнийг цаазаар сүхийг ав” (Б.Баярсайхан, 2002, хууд. 73) ... “бас хүрээ хаана зассан газраас зэрэгчлэн хойд бие нь Сэлэнгээс уламжлан Ар толби, Нам даваа, Нарийн, Орхон, Чандагатайн хяр, Шувуутын хяр, Сангийн даваа, Цулхар эднээс наашхи газрын амьтныг алахгүй. Хэрэв алваас хуучин цаазын ёсоор болох буй.” , “Ер сар бүрийн найман шинэ, арван таван, хорин таван, гучин эд өдөрт юм бүү ал. Давж алваас мөн тэр алсан юмыг үзсэн хүн гэрчилж байж зарганд хүрч ав.” , “бас эмгэг гэмгүй морь, хонгор галуу, могой, мэлхий, ангир, нялх, янзага, болжмор нохой эднийг бүү ал.” (Б.Баярсайхан, 2002, хууд. 74), ... “хэн хүн түймэр алдваас хэдэн хүн бөгөөс төдий хөлийг аваад, юу түлбээс түүнийг төлөөд, алданги нь тав буй. Алдагч хүн өөрөө унтрааваас хөл алданги үгүй. “Улс дунд түймэр шатваас аль ойрхи улс зартай, заргүй унтраа... Хэн хүн зар тасалбаас энэ хэргээр баалах буй.; “хэн хүн нүүсэн нутгийн галыг унтраа” (Б.Баярсайхан, 2002, хууд. 82) гэх мэтээр монголчуудын ахуй амьдралдаа гаргадаг байгалийг доройтуулдаг үйлдлүүдийг нэг бүрчлэн зохицуулахыг хичээж байжээ. Ялангуяа гал түймрийн үед заавал албадлагаар биш сайн дураараа очиж түймэр унтраахыг хуульчилжээ.

Дүгнэн үзвэл, XVI-XVIII дугаар зууны үе бол төр, эрх зүйн түүхийн хувьд улс төрийн бутралын үе бөгөөд манжийн эрхшээлийн үе, Монголд бурхны шашин хамгийн их идэвхжиж бурхны шашин, соёл монголчуудын амьдралд гүнзгий нэвтэрч, тийнхүү нэвтрүүлэхийн тулд нийгэм улс төрийн хувьд төрөл бүрийн арга хэмжээг бодлогоор авч хэрэгжүүлсэн үе болно.

Тиймээс хууль цаазын бичгүүддээ бурхны шашны үзэл санааг тодорхой хэмжээгээр тусгаж, амьтны амь хөнөөхийг хориглосон, мацаг барих өдрүүдийг тодорхойлсон, бурхны

⁴⁴ Эдгээр хуулбар эхүүд Үндэсний төв номын сангийн гар бичмэлийн фондод хадгалагдаж буй.

шашны зан үйлийн үед түүний үзэл санаатай харшлах үйлдэл үйлдэхийг хорьсон зүйл заалтууд туссан байна

Монгол дахь бурхны шашны хөгжил, дэлгэрлийн гуравдугаар үе нь өмнөх үеүдтэй харьцуулахад цар хүрээний хувьд өргөн, нийт ард олны дунд нэвтрэхдээ үзэл санаа, зан заншилд нь нөлөөлж, ялангуяа хууль цаазын бичигт нь бурхны шашны үзэл санаа тусгалаа олсон онцлогтой юм. Тэр нөлөө өнөө хэр хадгалагдсаар байгаа болно. Аливаа хуулийн үзэл баримтлал нь хуулийн агуулгаа тодорхойлж, тэр дагуу туссан зүйл заалт нь бүх нийтэд мөрдөгддөг тул хэвшиж тогтох нь ч зүй ёсны хэрэг юм.

Бурхны шашны үзэл сургаалд буян, нүглийн тухай сургаал буюу сайн, муугийн тухай үзэл санаа чухал байр суурьтай. Буддын сургаалд үйлийг “ерөнхийлөн хурааваас нүгэл, буян алин нэгэн болох” (ЗонховЛувсандагва, 2004, хууд. 188) буюу буян, нүгэл хэмээн ангилна. Бурхны шашинтан нь гурван үүдний үйлийг үйлдэхдээ (бие, хэл, сэтгэл) амьтны амь таслах тэргүүтэй “арван хар нүгэл”-ийг тэвчих нь арван цагаан буян-сайн үйл болдог хэмээн сургадаг. Тэрчлэн дэлхий ертөнц дээрх амьтан, ургамал, агаар, ус, хөрс, шороо нь хамтдаа нэгэн бүхэллэг ертөнц, байгалийг бүрдүүлдэг, шүтэн барилдлагат чанартай гэж үзнэ. Байгаль, юмс үзэгдлийн шүтэн барилдлагатай байдлыг “эх болсон зургаан зүйл” хэмээх ойлголтоор томъёолж тайлбарладаг.

Бурхны шашны энэхүү сургаалын нөлөөгөөр амьтан хөнөөхийг хориглож, хууль цаазаараа баталгаажуулж байсан монголчуудын энэ хандлага нь байгаль хамгаалах хийгээд байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад ач холбогдолтой явж иржээ. Ер нь хүн агнасаар цөөрсөн, утсан амьтны төрөл маш олон билээ.

Ном зүй

Сурвалж бичиг:

1. *Юань Улсын Судар. 102 дугаар дэвтэр. УТНС дахь гар бичмэл.*
2. *Алтан ханы цааз.*
3. *Хутугтай сэцэн хунтайжийн цааз*
4. *Халхын цааз эрхэмжийн бичиг*
5. *Монгол Ойрадын Их цааз.*
6. *Баруун хүрээний Халх журам.*
7. *Чакраварди Алтан хааны тууж. Хөрв. Д.Заяабаатар. (2006). УБ.*

Судалгааны бүтээл, эмхэтгэл:

1. Ч.Жүгдэр. (1987). *Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ (Нэн эртнээс XIV зуун).* УБ.
2. С.Жалан-Аажав. (1995). *Халх журам.* УБ.
3. Э.Авирмэд. (1997). *Монгол хууль.* УБ.
4. О.Амархүү. (2000). *Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, уламжлал.* УБ.
5. Б.Баярсайхан. (2002). *Монголын төр эрх зүйн түүх (Дээж бичиг) I боть.* . УБ.
6. Зонхов Лувсандагва. (2004). *Их бодь мөрийн зэрэг. Орч. Т.Булган.* УБ.
7. Сайшаал. (2008). *Чингис хааны товчоон I боть. Хөрв. Ш.Чоймаа.* УБ.
8. Ц.Минжин. (2009). *Их засаг (Түүх, эрх зүйн шинжилгээ).* УБ.
9. Ж.Болдбаатар нар. (2011). *Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал.* УБ.
10. Д.Идэр. (2019). *Их Юань хэмээх Их Монгол Улс. Монголын Эзэнт гүрний түүх. Дэд боть.* УБ.

Influence of the Buddhist teaching on nature conservation concepts reflected in Mongolian legal documents in XVI-XVIII centuries

As naturalists see, the reason for an increasing number and frequency of various natural disasters faced by the mankind is related not only to natural phenomena, but a human overconsumption and human activities that harm the nature. They view that it became the main condition for destruction of the virgin state of the mother nature, which is the basic condition of human existence. That is why the mankind as a whole is steadily taking measures to preserve the earth and prevent loss of its resources.

Organizations responsible for protecting the world's cultural heritage have taken into account the fact that environmentally friendly knowledge and methods are preserved in an open and hidden forms in the traditional knowledge, culture, lifestyle and behavior of the people. They research it, disseminate results to the general public and work to bring nature conservation to a new level. The UN agency on Education, Culture and Science - UNESCO is a clear example of this, and universities and research institutions play a special role in this. In general, applying any knowledge meaningfully to oneself and the mother earth is the basic requirement of knowledge application.

Mongols have had a variety of knowledge, methods and practices for nature conservation. The concepts, methods, and practices of nature conservation were legalized to support nomadic economy and lifestyle, which was reflected in the legal documents of the Mongolian state, starting with the Ikh Zasag- Yasa- the Code of Laws and Ordinances by Chingis Khaan. In addition, the concept of nature protection and articles in those laws have been influenced by the Buddhist concepts, which have been introduced in Mongolia earlier.

Especially the third wave of Buddhism in Mongolia was wider in scope compared to the previous two periods. It spread among the whole nation, not limited only to the circle of kings and noblemen and was adapted and developed in the everyday lives of Mongolian. In other words, one of the ways in which the teachings of Buddha have influenced all spheres of life for Mongols was the concept of communicating with the nature and lovingly protecting it, which is illustrated by legal sources such as the Khalkha Law.

The present article examines how the teachings of this religion were reflected in the nature conservation ideas of Mongolians, based on relevant legal documents during the third wave of Buddhism in Mongolia.